



БҮЛЭГ 3. ЭРХ ЗҮЙ



ЭРХ ЗҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?

Эрх зүйг хамгийн ерөнхий байдлаар нийгмийн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний тогтолцоог судалдаг шинжлэх ухаан гэж тодорхойлж болно. Эрх зүй бол тухайн хүн амын үндсэн бүх бүлгийн нийтлэг хүсэл зоригийг юм уу тэдгээрийн доторхи төрийн засаглалд ноёрхох байр суурьтай байгаа тийм бүлгийн өвөрмөц хүсэл зоригийг төрийн хүчээр хуульчлан батагасан нийгмийн хэм хэмжээнүүдийн тогтолцоо юм.

- ХҮНИЙ ЭРХ БА ҮНДСЭН ХУУЛЬ
- ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ХУУЛИАР ХАМГААЛАХ НЬ
- ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ
- ЗАХИРГАА, ИРГЭДИЙН ХООРОНДЫН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НЬ
- ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН МЕХАНИЗМ
- ШҮҮХ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ

3.1 Хүний эрх ба Үндсэн хууль

Нийгмийн гишүүн бүрийн амь бие, эд хөрөнгийг нийтийн хүчээр сахин хамгаалах чадвартай нийгмийн холбооны хэлбэрийг олох хэрэгтэй бөгөөд гишүүн бүр энэ нэгдэлд нэгдэх ёстой. Ингэснээр гагцхүү өөрөө өөрийгөө захирч урьдын адил бусдаас хамааралгүй эрх чөлөөтэй үлдэнэ.

Жан жак Руссо

Т.Гоббс Төр бол “левиафан”

Ф.Бастиа Төр бол “татвараар сорон мөлжигч”,

Р.Нозик “Төр бол “хүний эрхийн гол дайсан”

Ж.С.Милль, Төр бол “зайлшгүй байх ёстой муу зүйл”


Хүмүүс байгалиас заяасан эрх чөлөөтэй. Гэтэл яагаад төр засагт захируулж, эрх чөлөөгөө хязгаарлуулдаг юм вэ? Хариулт маш тодорхой юм. Байгалиас заяасан эрх чөлөөгөө эдлэх нь таатай гэсэн үг биш. Хүмүүс бусдын халдлагад хэзээ ч өртөх боломжтой байдаг. Ийм учраас тэд өөртэй нь ижил аюулгүй байдлаа хангах хэрэгцээтэй байгаа хүмүүсийг олж нэгддэг.

Джон Локк

“Аливаа эрх мэдэл хүнийг эвддэг бол хязгааргүй эрх мэдэл хязгааргүй эвддэг.”

Лорд Актон (Английн түүхч)





Төр хүний эрхийг хамгаалах үүрэгтэй

Гэвч төр эсрэгээрээ хүний эрхийг зөрчих, иргэдийг хохироох тохиолдол цөөнгүй гарах болсон.

Гэтэл хэмжээгүй эрхт засаг, төрийн дур зорго, үйлдэл, үйл ажиллагаа нь иргэдийн эрхийг үл тоомсорлох, зөрчих

Хүмүүс өмчөө хамгаалуулах, амар тайван, аюулгүй амьдрах, эрх чөлөөтэй байх эрхээ баталгаажуулахын тулд төрийг бий болгосон.





НТӨ IV зуунаас хүмүүс жам ёсны эрхийн талаар ярьж тэмцэж ирсэн хэдий ч хүний эрхийн хамгаалалт хангалттай байсангүй.

Учир нь хүний эрхийг зөвхөн зарлан тунхаглах нь хангалтгүй, харин түүнийг хамгаалах тогтолцоог бий болгох чухал юм.



ЗАСАГЛАЛЫН ЭРХ МЭДЭЛ






Эрхзүйд захирагдах ёс

Аливаа хууль, дүрэм, журам бол түүний тогтоож байгаа байгууллага, албан тушаалтны хүсэл зоригийн илэрхийлэл мөн. Эдгээр баримт бичгүүдийг Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон аль нэг байгууллагаас гаргадаг. Ийнхүү гаргахдаа эрхзүйн үндсэн зарчмуудад тулгуурладаг. Тухайлбал:

- ✓Шударга
- ✓Хүнлэг
- ✓Энэрэнгүй байх
- ✓Хүүхдийн эрх ашгийг зөрчихгүй байх гэх мэт.





Үндсэн хуульт ёс

Эрх зүйд захирагдах ёсны дагуу орчин цагийн үндсэн хуульд дараах зарчмыг удирдлага болгодог.

- ✓ Засаг, төрийн эрх мэдлийг хуваарилах
- ✓ Хүний эрхийг баталгаажуулах
- ✓ Ардчилсан дэглэм, бүгд найрамдах засаглалыг хүлээн зөвшөөрөх
- ✓ Эрхзүйт төрийн үндсийг бэхжүүлэх
- ✓ Хүнлэн энэрэнгүй байдлыг бий болгох
- ✓ Иргэний нийгмийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх г.м





МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛЬ

Үндсэн хууль нь засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй, хамгийн дээд хүчин чадалтай, засаг, төрийн гол хууль юм.



Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /цаашид "Цэц" гэнэ/ бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн

<https://www.conscourt.gov.mn/>



Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын Дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

1/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

2/зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

3/Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

4/Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

5/ард нийтийн санал асуулгын талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

6/Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх.



1/Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн эсэх;

2/Улсын Их Хурлын дарга, гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх;

3/Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх;

4/Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;

5/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл байгаа эсэх.

6/Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл байгаа эсэх.



3.2 ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ХУУЛИАР ХАМГААЛАХ НЬ



АШИГЛАХ

- ТУХАЙН БАЯЛГИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЭХ

ЭЗЭМШИХ

- БҮРЭН ХАРАА ХЯНАЛТАНДАА БАЙЛГАХ

ЗАХИРАН
ЗАРЦУУЛАХ

- ТУХАЙН БАЯЛГИЙН ХУВЬ ЗАЯАГ НЬ ШИЙДВЭРЛЭХ

Ул үндэстэй авч үзэх юм бол эрх гэж байхгүй зөвхөн “өмчлөх эрх” байдаг.

1. Хувь хүн өөрөө өөрийнхөө эзэн, өөрийгөө мэддэг
2. Хүний аливаа эрх өмчлөх эрх дээр хураангуйлагддаг.





Оюуны өмчийг хамгаалах гол
эрх зүйн хэм хэмжээ нь
Зохиогчийн болон Патентийн
тухай хууль юм.

Эдийн бус баялагт оюуны өмч,
зохиогчийн эрх, патент, нэр,
нэр төр, алдар хүнд, ажил
хэргийн нэр хүнд зэрэг
хамаарах юм. .

Эдийн баялаг гэдэгт хөдлөх
болон үл хөдлөх хөрөнгийг
ойлгоно.



16.3

“хөдлөх үл хөдлөх хөрөнгө
шударгаар олж авах, эзэмших,
өмчлөх, өв залгамжлуулах”

Иргэний хууль

Өмчийн харилцааг
нарийвчлан зохицуулсан.

Эдийн болон эдийн бус
баялагтай холбоотой
харилцааг тус хуулиар
зохицуулж өгсөн.

ӨМЧЛӨХ ЭРХ ХЭРХЭН ҮҮСЭХ ВЭ?



Үйл ажиллагаа 3.5. <http://www.legalinfo.mn/law/details/299> линкээр зочилж, Иргэний хуулийн 115-118 дугаар зүйлийг уншиж, дараах тохиолдлуудыг шинжлэн судлаад хууль зүйн үндэслэл бүхий тайлбар хийнэ үү.

№	Эд хөрөнгийг өмчлөх эрхтэй юу?	Тийм	Үгүй	Тайлбар
1	Иргэн "Д" автобусанд явж байхдаа 1.5 сая төгрөгийн үнэтэй гар компьютер олсон байна.			
2	Иргэн "Ч" Зөвлөлтийн цэргийн анги Монголоос гарах үедээ орхисон гахайн байрыг сумын захиргаанд мэдэгдэж, засаж, сэлбэж 7 жил тасралтгүй эзэмшсэн.			
3	Иргэн "Э" Онгийн хийдийн тууринд дарагдмал үнэт эд зүйл байдгийг бусдаас сонсож өөрөөсөө хөрөнгө хүч гарган хайгуул хийж, эрсэн зүйлээ олоход түүний дотор түүхийн дурсгалт зүйл ч байсан байна.			
4	Малчин "А" шуурганд туугдаж яваа 300 хонь олоод орон нутгийн захиргаанд мэдэгдэж, 1.6 жил маллав. Гэтэл алдуул хонины эзэн "Б" ирж бүх малаа төлийн хамт авна гэхэд А малын төл бол миний өмч гэв.			
5	Иргэн А-г гудамжинд явж байхад үл таних Б хөөрөг худалдаж авахыг санал болгожээ. А хөөргийг үзээд худалдаж авсан. Уг хөөргийг Б нь Д-ээс хулгайлсан бөгөөд энэ талаар А огт мэдээгүй.			

Өмчлөх эрх үүсэх үндэслэл



Гэрээнд заасан үндэслэл



Худалдах худалдан авах гэрээ




Арилжааны гэрээ



Бэлэглэлийн гэрээ



Зээлийн гэрээ



Өмчлөх эрх үүсэх үндэслэл



Хуульд заасан үндэслэл



Эзэнгүй юм олж авах




Гээгдэл эд хөрөнгийг олж авах




Алдуул мал олж авах



Дарагдмал үнэт зүйл олж авах г.м



Өмчийн харилцаанд зайлшгүй анхаарвал зохих асуудлууд



ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

2013-оны 09-сарын 18-ний өдөр

Дугаар: 01/13

Улаанбаатар хот

Нэг талаас “Эн Эн Эм Эй” ХХК” /цаашид ажил олгогч гэх/ нөгөө талаас УЗ90060502 тоот регистрийн дугаартай ... овогтой ... /цаашид ажилтан гэх/, /цаашид хамтад нь талууд гэх/ нар нь Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуулийн дагуу харилцан тохиролцож, энэхүү гэрээг дараах нөхцлөөр байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү гэрээгээр талуудын эдгэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох бөгөөд Хөдөлмөрийн тухай Монгол улсын хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан Хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн харилцааг зохицуулсан бусад эрх зүйн актууд нь энэхүү гэрээний хууль зүйн үндэслэл болно.

ХОЁР. АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

- 2.1 Ажлын байрны буюу албан тушаалын нэр: **Маркетингийн мэргэжилтэн**
- 2.2 Ажилтны гүйцэтгэх ажил, үүрэг: Ажилтан нь энэхүү гэрээний хавсралт болох “Ажлын байрны тодорхойлолт”-нд заасан ажил үүргүүдийг хийж гүйцэтгэнэ.
- 2.3 Хөдөлмөрийн нөхцөл: **Хэвийн**

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1 Энэхүү гэрээг Ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухай бүр үнэлж дүгнэх, улмаар компанийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Ажил олгогчийн санаачлагаар **2013-оны 07-дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 2014-оны 07-дугаар сарын 09-ний өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар** байгуулав.
- 3.2 Талууд гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах талаар хэн нэгэндээ санал тавиагүй бол энэхүү гэрээний хугацааг нэг жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно. Энэхүү нэг жилийн хугацаанд гэрээг талуудын аль нэгний саналаар цуцлаагүй бол уг гэрээний хугацааг дахин нэг жилээр сунгасанд тооцно.
- 3.3 Ажилтан энэхүү гэрээг цуцлах тухай хүсэлтийг 2 сараас доошгүй хугацааны өмнө Ажил олгогчид бичгээр өргөдөл гарган мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв талууд тохиролцсон бол
- 2
- сараас өмнө гэрээг цуцалж болно.

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Н.ЦЭРЭНЭАТ

МОНГОЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТЭРГҮҮН

Б.ЭРДЭНЭ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ,
МОНГОЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ ХООРОНДЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Иргэний хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, “Төрийн бус байгууллагын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн,
Нэг талаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нөгөө талаас Монголын байгаль орчны иргэний зөвлөл /цаашид “МБОИЗ” гэх/ дараах зүйлийг харилцан тохиролцож, 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаатай энэхүү ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ /цаашид “гэрээ” гэх/ байгуулав.

1.2. Цаашид энэхүү гэрээг үндэслэн хамтран гүйцэтгэх ажлуудыг хоёр тал төсөл болон бусад арга замаар гүйцэтгэлийг хангаж ажиллана.


Хоёр. Гэрээний зорилго

2.1. Монгол Улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг арилгахад туслалцаа үзүүлэх, хөгжлийг байгаль орчинд сөрөг нөлөө багатай төлөвлөх, хэрэгжүүлэх, салбарын үйл ажиллагааны чиг үүрэг, үйл ажиллагааг бүх талаар дэмжих, хэрэгжилтийг хангахад байгаль орчны төрийн бус байгууллагуудын оролцоо, санал санаачлага, үйл ажиллагааг чиглүүлэх, тэдний хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлэхтэй холбогдсон асуудлыг хамтын оролцоотой шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

Гурав. БОА ЖЯ-ны хүлээх эрх, үүрэг

3.1. Байгаль орчны чиглэлийн Төрийн бус байгууллага /ТББ/-ууд, иргэд, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг МБОИЗ-ийн ажлын албанд хариуцуулан гүйцэтгүүлж, ажлын байр, сургалтын танхим, тоног төхөөрөмжөөр хангана.

3.2. Байгаль орчны чиглэлийн ТББ-уудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор МБОИЗ-ийн ажлын албыг хараат бус, тогтвортой санхүүжилттэй болгоход дэмжлэг үзүүлнэ.



Иргэний хэргийн анхан шатны шүүх хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор хэргийг шийдвэрлэх бөгөөд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болохоор ИХШХШТХ-д зохицуулсан байна.

Өмчлөх эрхээ хэрхэн
хэрэгжүүлж хамгаалах вэ?





Үйл ажиллагаа 3.6. Тохиролдол шинжлээрэй.

Нэг. Иргэн А малаа бэлчээрт гаргахдаа хөрш Б-гийн өмчлөлийн газраар дайрч өнгөрдөг. Үүнээс өөр гарц байхгүй. Гэтэл хөрш Б хүнсний ногоо тарихаар шийдэж, А-г ногооны талбайд мал оруулахыг хориглосон.

Асуулт:

- А нь эрхээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Хоёр. Иргэн Д Говь-Алтай аймагт оршин суудаг. Тэр "Нарантуул" захаас 70 000 төгрөгөөр өвлийн гутал худалдан авч 3 өдөр өмссөн байна. Гэтэл гутлын ар талын хатуулгыг буруу нааснаас болж урагдсан. Иргэн Д худалдагчтай уулзаж энэ талаар хэлэхэд, "энэ гутлыг би үйлдвэрлээгүй, надаас шинэ гутал авсан, одоо өмсчихсөн тул буцаах, солих боломжгүй" гэв. Худалдагч Баянзүрх дүүрэгт оршин суудаг.

Асуулт:

1. Худалдагчийн тайлбар үндэслэлтэй юү?
2. Иргэн Д-ийн ямар эрх зөрчигдсөн бэ?
3. Иргэн Д эрхээ хэрхэн хамгаалах вэ?
4. Хэрэв та А болон Д байсан бол асуудлыг шийдвэрлэхийн тулд юу хийх вэ?

Асуудлыг шийдэх хувилбар

01

ТОХИОЛДОЛ 1.


Иргэн А нь малаа бэлчээрт гаргахын тулд Б-тэй зөвшилцөн түүний газрыг хязгаартай ашиглах гэрээ байгуулж болно.

Иргэний хуулийн 151-р зүйлээр зохицуулсан

02

ТОХИОЛДОЛ 1.

Харин А нь Б-ын хэсэг газарт нарийн зам гаргаж, хашаа татаж, малаа бэлчээрт гаргаад хариуд нь Б-д нь мөнгөн төлбөр төлөх замаар харилцан тохиролцож болох юм.





Өмчлөх эрх зөрчигдсөн
тохиолдол нь гэмт хэргийн
шинжгүй эсвэл захиргааны
байгууллага, албан
тушаалтны хууль бус
шийдвэр, үйл ажиллагаатай
холбоогүй бол иргэний эрх
зүйн зөрчил болно.



**Өмчлөх эрхээ хэрхэн хэрэгжүүлж,
хамгаалах вэ?**

Иргэн, хуулийн этгээд
Иргэний хэргийн шүүхэд
нэхэмжлэл гаргаж, өөрийн
эрхийг хамгаалдаг.



НЭХЭМЖЛЭЛ

Иргэний хэргийн шүүхэд хандаж эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой маргаж байгаа буюу зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалахын тулд анхан шатны шүүхээр дамжуулан эрх зөрчигчид тавьж буй шаардлага юм.



Нэхэмжлэлийг буруутай гэж үзэж байгаа хүнийхээ оршин суугаагазрын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргана. Нэхэмжлэл гаргахдаа хуульд заасан бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай болдог.

Нэхэмжлэлийн
бүрдүүлбэр

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХДАА ЮУ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?



Нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа

Нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, утасны дугаар, хуулийн этгээд бол оршин байгаа газар

Эрх зөрчигчийн буюу хэргийн хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг

Нэхэмжлэлийн үнэ буюу хэдэн төгрөг нэхэмжилж байгаа талаар бичих, хэрэв эл хөрөнгө гаргуулах нэхэмжлэл бол зах зээлийн үнийг дүнг бичих

Улсын тэмдэгтийн хураамж буюу шүүхээс үйлчилгээ үзүүлсний хөлсийг хууль заасан хэмжээгээр төлсөн баримт

**ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ 1-Р ШҮҮХЭД
ХҮСЭЛТ ГАРГАХ НЬ**

... оны... сарын ...өдөр

Эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах тухай

Нэхэмжлэгч: Боржигон овогт Г.Н
ХУД-ийн XX хороо, XX байр XX тоот Утас:000000
Хариуцагч:Харчин овогт С.Ц
ХУД-ийн XX хороо, XX байр XX тоот Утас:000000

Г.Н би 200.. онд С.Ц-тэй хамтран амьдарч эхлэсэн. Гэвч С.Ц нь 200..оны ...сараас эхлэн намайг элдвээр хэлж хараах, зэргээр айлган сүрдүүлдэг байснаа 200.. оны .. сараас гадуур олон хоногоор сураггүй тэнэж, алга болж ирчихээд хэрүүл зодоон хийж, гар хүрч өшиглөж зодох зэргээр байнга дарамтлах болсон.

Хүчирхийлэл нь сэтгэл санааны, эдийн засгийн хэлбэрээр үйлдэгддэг. Архи дарс хэрэглээгүй үедээ ч уурлахаараа гэрийнхээ эд хогшилыг эвдэх, шатаах зэрэг бүдүүлэг үйлдэл байнга гаргадаг. Урьд өмнө нь энэ асуудлаар хууль хяналтын байгууллагад хандаж байгаагүй. Ах дүү нартаа ч хэлэлгүй нууж явдаг байсан. Сүүлийн үед гар хүрч зодох нь бүр ихэсч 200.. оны ... сард хутга гаргаж, гэрийнхээ хаалгыг түгжиж байгаад эхлээд чамайг ална, дараа нь өөрийгөө ална гэж удаа дараа дарамталсан. Хамгийн сүүлд дахин сүрдүүлэхэд нь охиноо авч гарч зугатааж, хүчирхийлэлийн эсрэг төвийн хамгаалах байранд байрласан.

Харъяа хорооны цагдаад тэр даруй зодуулсанаа үзүүлж 7 хоног хорих арга хэмжээ авхуулсан. Түүнээс хойш уулзалдахгүй зугатааж ах дүү нарынхаараа голдуу байсан. Гадуур гарахдаа ч айдас түгшүүртэй, хаана тааралдчих бол, яачих бол гэж байнга айж явдаг болсон.

Гэтэл нэг өдөр ажлаасаа тараад явж байтал араас гэнэт гарч ирээд явуулахгүй хоргоогоод, дуугарах юм бол ална шүү гээд хүүхэдтэйгээ уулзуулахыг шаардахад нь дүүгийн дээ дагуулж очсон. Хүүхэдтэйгээ уулзаж байх хооронд нь гарч цагдаа дагуулж иртэл охиноо аваад явсан байсан бөгөөд одоог хүртэл охиныг минь өгдөггүй. Охин минь ханиад хүрээд бие нь тааруу байгаа бөгөөд гэрээрээ эмчилгээ хийлгэж байсан юм, одоо тэр эмчилгээ нь тасарчихлаа.

Цаашид энэ байдал үргэлжлэх юм бол миний болон охины маань амь нас, эрүүл мэнд, хүмүүжилд ноцтой хохирол учруулж болзошгүй байх тул Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн дагуу арга хэмжээ авч өгнө үү

Бүрдүүлэх материал:

1. 1.Хүсэлт нэг хувь

1. 2.Хүүхдийн төрсөний гэрчилгээний хуулбар нотариатаар гэрчлүүлсэн.

**Дүүргийн иргэний хэргийн анхан шатны нэгдүгээр шүүхэд
нэхэмжлэл гаргах нь**

.... оны ... -р сарын ...-ны өдөр

Хариуцагчийг эрэн сурвалжлуулах тухай

Нэхэмжлэгч: “Хас банк”

Хан-Уул дүүрэг, 6 дугаар хороо, дэх тооцооны салбар

Утасxxxxxxx

Иргэн Б.Батаа нь Хас банкны 09дүгээр салбараас 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 400032568 тоот зээлийн гэрээгээр 1.000.000 / нэг сая / төгрөгийг 30 хоногт 3.5 хувийн хүүтэй, эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 12 сарын хугацаатай буюу 2007 оны 12 дугаар сарын 15-ны өдөр гэрээ дуусгавар болох нөхцөлтэйгээр авсан. Зээлдэгч нь зээл авах үедээ Хан-Уул дүүргийн 7-р хороо, Жаргалантын задгай тоотод оршин сууж, Баянгол дүүрэгт байрлах “Солонго”трейд ХХК-ий харъяа 1000 нэрийн барааны дэлгүүрт лангуу түрээслэн ажиллуулж орлого олж байсан бөгөөд эхний сарын зээлийн эргэн төлөлтөөс эхлэн зээлийн гэрээний үүргээ зөрчин байнга хугацаа хоцроон төлж байгаад 2007 оны 05 дугаар сараас эхлэн зээлийн төлбөрөө хийхээ больсон. Мөн түрээсийн лангуу ажиллуулахаа ч больсон байна. Одоо түүний оршин суух хаяг нь тодорхой бус хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа тул эрэн сурвалжилж өгнө үү.

/Эрэн сурвалжлах гэж байгаа хүнийхээ талаарх мэдээлэлийг дэлгэрэнгүй бичнэ/

Нэхэмжлэлд:

1. Нэхэмжлэл 1 хувь

2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт 70200төгрөг /

3. Нэхэмжлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

4.Байгууллагыг төлөөлж байгаа бол итгэмжлэл 1 хувь

5. Зээлийн болон барьцааны гэрээ

6. Эрэн сурвалжлуулах гэж байгаа этгээдийн иргэний үнэмлэх, зураг

7. Тухайн этгээдийн хамгийн сүүлд оршин сууж байсан хорооны Засаг даргын тодорхойлолт

/Нотлох баримтыг эх хувиар нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргаж өгнө/

Нэхэмжлэл гаргасан / Гарын үсэг / А.Б

НИЙСЛЭЛ ХОТЫН ХЭМЖЭЭНД
2019 оны 1-р улирал



Гэмт хэргийн илрүүлэлт 16.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс илрүүлэлт 6 хувиар өссөн.



-36.2%
Хулгайлах



-42.7%
Дээрэмдэх



-13.3%

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг



Хичээлийн сэдэв:

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх

Шударга шийтгэл бол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шилдэг арга мөн. И. Кант



НИЙГЭМ СУДЛАЛ XI



Улаанбаатар хот
2018 он

Тохиолдол 1.

Иргэн Ж-г ажилдаа явсан хойгуур түүний байшингийн цонхоор Б хоёр удаа орж эд зүйлийг нь хулгайлж авсан байна. Б-гийн үйлдлийг хамар хашааны иргэн О харсан боловч энэ талаар хэнд ч хэлээгүй. Дараагийн өдөр нь Ж ажлаасаа чөлөө авч гэртээ Б-г хүлээв. Б дахин орох үед Ж түүнийг цохиж биед нь хүндэвтэр гэмтэл учруулжээ.



Хэнд хохирол учирсан бэ?



Хэнд гэм хор учирсан бэ?



Хэн гэмт хэрэг үйлдсэн бэ?



Хэрэв та Ж байсан бол ямар үйлдэл хийх вэ?



Хэрэв та О байсан бол ямар үйлдэл хийх вэ?



Францын философич, социологич Э. Дюркгейм (1858-1917)

“Аливаа нийгэмд гэмт хэрэг, зөрчил байнга оршсоор ирсэн. Олон зууны турш хүн төрөлхтөн үүнийг үгүй болгохыг хичээсэн ч соёл иргэншилд төвлөрсөн амьдрал буюу хот суурин бий болохын хэрээр улам нэмэгдсээр байна” гэж дүгнэжээ.

Эрх зүйн
зөрчил

Гэмт
хэргийн

Гэмт
хэргийн бус



Эрхзүйн зөрчил гэж хууль, дүрэм, журмыг зөрчсөн нийгэмд хор аюултай, хууль эрх зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл **эс үйлдлийг** хэлнэ.

(**Эс үйлдэл гэдэг нь** хуульд заасан үүргээ гүйцэтгэхгүй байхыг хэлнэ.)

ГЭМ ХОР ГЭЖ ЮУ ВЭ?

ГЭМ ХОР

Хохирол хор уршиг
гэсэн ойлголтыг
багтаадаг.

ХОХИРОЛ

Шууд бий болох үр
дагавар

ХОР УРШИГ

Хохирлын улмаас бий
болдог.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН БЭЛГЭДЭЛ

“Цагаан шонхор” нь цагдаагийн байгууллагын сүр хүч, цог хийморийн илэрхийлэл юм.

ШОНХОР ШУВУУ: Эзэн Чингис хаан Шонхор шувууг хурд хүч, зориг, авхаалж самбаа, эрч хүчний бэлгэдэл гэж үзэж ирсэн бөгөөд Монголчуудын эрхэмлэн дээдлэн ирсэн түүхэн уламжлалыг хадгалах, цагдаагийн байгууллага Шонхор шувуу мэт байхыг бэлгэдсэн. Бэлгэдлийн Шонхор шувууг далавчаа дэлгэсэн дүүрэн татсан нум мэт дүрсэлсэн нь мөн хурд хүчийг бэлгэдсэн.

УЛААН ХҮРЭЭ: Мандан бадарч, дүрэлзэн асах, галыг бэлгэдсэн.

СУМ: Дүүрэн татсан нум хэлбэртэй Шонхор шувууны дээд хэсэгт байрлах таван сум нь цагдаагийн ажилтны таван мэдрэхүй хурц байг мөн Алунгоо эхийн домогт өгүүлсэн эвийн бэлгэдлийг давхар агуулсан.

СУУРЬ ЦЭНХЭР ӨНГӨ: Үргэлж өндөр дээд хөх тэнгэр мэт байхыг бэлгэдсэн.

БИЧЭЭС: Уламжлал шинэчлэлийг хослуулах үүднээс уйгаржин Монгол бичгээр бэлгэдлийн зүүн талд МОНГОЛЫН, баруун талд ЦАГДАА гэж доод хэсэгт латин үсгээр POLICE гэж бичсэн.



МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА



3.4. Захиргаа, иргэдийн хоорондын маргааныг хянан шийдвэрлэх нь



Монгол Улсын анхан шатны шүүхүүд 2018 онд эрүүгийн 12551 хэрэг, иргэний 48155 хэрэг, захиргааны 1638 хэрэг, нийт 62344 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, 12904 зөрчил, зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулжээ

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан.

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

2

-НАЙЗЫГ НЬ АЖЛАА
ӨГ ГЭНЭ ЭЭ.

1

- ЗА НАЙЗ МИНЬ ЮУНД
ИНГЭЖ ГУНИГЛАВ АА?

5

-МЭДЭХГҮЙ ЭЭ. УЛС
ТӨРИЙН ТОМИЛОГОО ЮМ
БАЙХ...

3

- БАЙРНЫ ЗЭЭЛТЭЙ
БАЙДАГ...ОДОО ЯАДАГ
ЮМ БИЛЭЭ...

4

- ЯМАР ҮНДЭСЛЭЛЭЭР
АЖЛААС ЧИНЬ
ЧӨЛӨӨЛЖ БАЙГАА
ЮМ БОЛ?

Захиргаа, иргэдийн хоорондын маргааныг хянан шийдвэрлэх нь

Захиргаа нь захиргааны актыг дангаар батлан гаргах давуу эрхтэй учир түүний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт чухал байдаг. Энэ хяналтыг **Захиргааны хэргийн шүүх** хэрэгжүүлдэг.

01

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

02

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

<https://www.legalinfo.mn/law/details/284>



ЗАХИРГААНЫ ХЭРЭГ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА



- ❑ Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.
- ❑ МУ-ын иргэн төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.
(Үндсэн хууль)

ГОМДОЛ

Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг **ГОМДОЛ** гэнэ.



Иргэн хуулийн этгээдээс захиргааны байгууллагад гомдол гаргах хугацааг 30 хоногийн дотор байхаар тогтоож өгсөн.

ГОМДЛЫГ
ШИЙДВЭРЛЭХ



ХЭРГИЙН ОРОЛЦОГЧ


Гомдол гаргаж буй иргэн,
хуулийн этгээд, хариуцагч
болох захиргааны
байгууллага, албан
тушаалтан, гуравдагч
этгээдийг хэлнэ.

**Захиргааны хэргийн урьдчилан
шийдвэрлэх ажиллагаанд оролцогч**

БУСАД ОРОЛЦОГЧ

Захиргааны байгууллага,
хэрэг урьдчилан шийдвэрлэх
ажиллагаанд туслах чиг
үүрэгтэй оролцож буй этгээд





Захиргааны хэргийн анхан шатны шүүх хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор хэргийг шийдвэрлэх бөгөөд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс эхний удаа 30 хүртэл хоногоор, хоёр дахь удаа 15 хүртэл хоногоор сунгаж болохоор ЗХШХШтХ-д зохицуулсан байна.



НИЙСЛЭЛИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ
ПҮРЭВГЭРЭЛИЙН ГЭРЭЛБААТАР

Утас: 99116078

2018.09.04 № 04
танай -ны № -т

Нэхэмжлэл гаргах нь

Нэхэмжлэгч: Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нар

Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сумын 7 дугаар баг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байр
Утас: 99116078

Хариуцагч: Монгол Улсын Сангийн сайд

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын 2 дугаар байр

Утас: 261176

Нэхэмжлэлийн шаардлага: Газрын тосны гэрээт 19, 21 дүгээр талбайгаас газрын тосны нөөц ашигласны төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгөөс 2015 онд 6,5 тэрбум, 2016 онд 6,5 тэрбум, 2017 онд 9,9 тэрбум төгрөгийг тус тус Газрын тосны тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.3 дахь заалтын дагуу ...тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд,төвлөрүүлэхийг даалгах тухай

Нэхэмжлэлийн утга: Дорнод аймгийн Матад, Халхгол сумын нутаг дэвсгэрт Газрын тосны гэрээт 19, 21 дүгээр талбайд 1992 оноос хойш газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явагдаж, дээрх тайлбайгаас Монгол Улсын газрын тосны олборлолтын 92 хувь буюу жилд дунджаар 1.000.000 /нэг сая/ тн түүхий газрын тосыг экспортолж байна.

Олборлолтын үйл ажиллагаанаас үүдэн Монгол Улсын төвөөс алслагдсан хил дагуу байршилтай Халхгол, Матад сумын нутагт амьдарч буй малчин иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлж, хүн, малын оршин тогдох нөхцлийг доройтуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "...байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна" гэсэн заалтын хэрэгжилт хангагдахгүй байна. Улмаар иргэд, олон нийтийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах үндсэн эрх зөрчигдөж байна.

Олон улсын жишигт байгалийн баялаг болох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр "роялти"-ийн тодорхой хувийг олборлолт, ашиглалтын нөлөөлөлд өртөж буй тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд нэмж хуваарилдаг зарчимтай бөгөөд Монгол улс ч энэхүү олон улсын жишгийн дагуу хууль зүйн зохицуулалтыг бий болгосон байдаг. Энэ нь Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь заалт юм.

Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь заалтын дагуу ашигт малтмалын олборлолт, ашиглалтын нөлөөлөлд өртөж буй бүс нутгийн байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалах, хэвээр хадгалах, нөхөн сэргээх иргэдийн амьдрах орчныг хадгалах, дэмжих буюу уул уурхайн ашиглалтаас үүссэн сөрөг нөлөөллийг арилгахад зориулагдах учиртай хөрөнгийг Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам Дорнод аймагт хуваарилах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим" гэж заасан байхад төсвийн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн яам, Сангийн сайд нь хууль биелүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах үүргээ биелүүлэхгүй байна.

Аймгийн иргэдийг төлөөлж байгаа хурлын төлөөлөгчийн хувьд орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх учиртай газрын тосны нөөц ашигласны төлбөрийн талаар мэдээлэл авахаар аймгийн Засаг даргад хандахад: "нутгийн захиргааны байгууллагаас газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутагт төвлөрүүлэхтэй холбоотой албан бичгийг Сангийн сайд, Ашигт малтмал, газрын тосны газарт удаа дараа хүргүүлэн, хандсан боловч одоо болтол шийдвэрлэгдээгүй байна" гэж мэдэгдсэн.

Уг асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа нь тус аймгийн Матад, Халхгол сумын иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөөр байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалтын дагуу тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж батлуулах эрх бүхий албан тушаалтан /Төрийн захиргааны төв байгууллага/ болох Сангийн сайдад Газрын тосны гэрээт 19, 21 дүгээр талбайгаас газрын тосны нөөц ашигласны төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгийг Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь заалтын дагуу ... тухайн орон нутагт /Дорнод аймаг, Матад сум, Халхгол сум/ хуваарилахыг даалгаж өгнө үү.

Холбогдох материалыг хавсралтаар хүргүүлэв.

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН:

ТӨЛӨӨЛӨГЧ П.ГЭРЭЛБААТАР

Ж.ЦОГТБААТАР

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ НЬ

2014.01.01

Улаанбаатар хот

Нэхэмжлэгч: Боржигон овогт Болдын Баатар,

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, А-р байр 5-6 тоот, Утас: 320000, 99090000, 88090000.

Хариуцагч: Баянгол дүүргийн татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Х.Бат.

Хаяг: Баянгол дүүрэг, 3-р хороо, Утас: 350000.

Нэхэмжлэлийн шаардлага: Баянгол дүүргийн татварын хэлтсийн Татварын улсын байцаагчийн 2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 301 тоот актыг хүчингүй болгуулах тухай.

Нэхэмжлэлийн утга: Б.Баатар би татварын байцаагчийн актыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бөгөөд дараах хууль зүйн үндэслэлээр уг актыг хүчингүй болгуулахаар энэхүү нэхэмжлэлийг гаргаж байна. Үүнд:

Монгол улсын Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 4-р зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “в”-ийн “нөхөн олговор, хөнгөлөлтийн орлого (унаа, түлш, хоол, байрны үнийн хөнгөлөлт гэх мэт)” гэсэн заалтыг 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон тул байрны үнийн хөнгөлөлтийг эдүгээ татвар ногдох орлогод тооцдоггүй билээ.

Иймд Баянгол дүүргийн татварын хэлтсийн Татварын улсын байцаагчийн 2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 301 тоот актыг хүчингүй болгож өгнө үү .

Хавсаргасан материал:

1. Нэхэмжлэл /2 хувь/,
2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
3. Татварын улсын байцаагчийн 301 тоот акт,
4. Татварын маргаан таслах зөвлөлийн 3 тоот тогтоол

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн маргаан;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн маргаан;
- Бүртгэлийн маргаан;
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн маргаан;
- Өрсөлдөөний маргаан;
- Сонгуулийн маргаан;
- Татварын маргаан;
- Төрийн албаны маргаан;
- Тендер, сонгон шалгаруулалтын маргаан;
- Хяналт, шалгалтын маргаан.



-ийг хамгаалах **Үндэсний** ба **Олон улсын** механизм

1993 оны Дэлхийн хүний эрхийн бага хурлаар баталсан Венийн тунхаглалд “Хүний эрх бол бүх хүнд заяасан төрөлх эрх бөгөөд хүний эрхийг хамгаалах нь төр засгийн байгууллагуудын анхдагч үүрэг юм” хэмээсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан билээ.

ХЭ-ийн талаар төрийн хүлээх үүрэг

Хангах

Хамгаалах

Ахиц дэвшил
гаргах

Хүндэтгэх



Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах нь төр засгийн сайн санааны үйлс бус, харин Үндсэн хуулиар төр засагт ард түмнээс ногдуулсан үүрэг юм.

Төр нь дотооддоо хүний эрхийг хангахдаа өөрийн тогтолцоог сайтар ажиллуулах үүрэг хүлээдэг. Эдгээр тогтолцоог нийтэд нь хүний эрхийг хамгаалах төрийн механизм хэмээн нэрийдэж байна.

Төрийн хүний эрхийг хамгаалах чиг үүрэг

Хууль тогтоох

Гүйцэтгэх

Шүүх



Үндэсний ТОГТОЛЦОО

Төрийн
байгууллагууд

Хүний эрхийн
үндэсний
байгууллагууд

Иргэний
нийгмийн
байгууллагууд

4 дүгээр зүйл.Шүүхийн эрхэм зорилго

4.1. Шүүх нь дараах эрхэм зорилготой:

4.1.1.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох;

4.1.2.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллыг хамгаалах;

4.1.3.хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх;

4.1.4.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх.

4.2.Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй.

